



ТЕЛЕВИЗҮҮДЭЭР НЭВТРҮҮЛЖ БАЙГАА ДОХИОНЫ ХЭЛ, ХАДМАЛ ТАЙЛБАРТАЙ НЭВТРҮҮЛГИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН АНАЛИЗ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз болон мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн хөтөлбөртэй арилжааны телевизүүдэд толорхой хөтөлбөрөө дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэх үүрэг хүлээлгэдэг. ХХЗХ нь эдгээр телевизүүдээс тухайн телевизээр нэвтрүүлэх дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай гаргах нэвтрүүлгийн төлөвлөгөөг хагас болон бүтэн жилээр гаргуулан авч хэрэгжилтийн байдлыг гаргаж байна. Телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөө боловсруулж, үе шаттайгаар жил бүр нэмэгдүүлж хэрэгжүүлэх үүрэгтэй.



Дүгнэлт хийхийн өмнө телевизүүдийн дохионы хэл, бичгэн тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлыг өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн ангилал тус бүрээр Хөтөлбөрт тавигдах шаардлага батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш буюу 2021 оноос 2025 оны байдлаар авч үзье. Жил бүрийн мониторингийн дэлгэрэнгүй тайлантай ХХЗХ-ны цахим хуудасны энэхүү <https://www.crc.gov.mn/rq-n-nevtr-leg/monitoringiin-tailan> холбоосоор орж танилцах боломжтой.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевиз нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй тул хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой хөтөлбөрөө дохион хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэх үүрэг хүлээдэг.



Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевиз 2021 онд 3700 цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлж байсан бол 2025 онд 5569 цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь 1.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг 2021 онд 382 цаг нэвтрүүлж байсан бол тогтмол өссөөр 2025 онд 2972 цаг нэвтрүүлсэн нь 7.8 дахин өссөн үзүүлэлтийг үзүүлж байна.

Харин одоо хөтөлбөрт тавигдах шаардлагаар үүрэг хүлээсэн арилжааны 26 телевизээр 2021-2025 онуудад дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлыг авч үзье.



Арилжааны телевизүүдийн дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг 2021-2025 онуудад нэвтрүүлсэн байдлыг харахад дохионы хэлтэй нэвтрүүлсэн нэвтрүүлэг жигд өссөн үзүүлэлттэй байгаа бол хадмал тайлбартай нэвтрүүлэг 2025 онд буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2025 оноос Улаанбаатар хотын арилжааны телевизүүдийг түүврээр мониторингийн хяналтад хамруулдаг болсонтой холбоотой юм.

Дараагийн ээлжинд телевизүүдийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг тухайн телевизийн хөтөлбөрт хэдэн хувь эзэлж байгааг 2025 оны 3, 4 дүгээр улирлын байдлаар авч үзье. Хүснэгт 1-д телевизүүдийн хөтөлбөрт эзлэх дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн дундаж хувь болон хамгийн өндөр үзүүлэлтийг харууллаа.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизүүдийн хувьд хөтөлбөрт эзлэх дохионы хэлтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн дундаж 4.3%-тай байгаа бол хадмал тайлбартай нэвтрүүлэг 2.5-2.8% үзүүлэлттэй байна. Харин арилжааны телевизүүдийн хувьд хамгийн сайн үзүүлэлт дохионы хэлний хувьд 3.1-4.3% байгаа бол хадмал тайлбартай нэвтрүүлгийн хувьд 4.3-5.6% байна.

Хүснэгт 1. Дохионы хэл, хадмал тайлбартэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн нийт хөтөлбөрт эзлэх хувь

Ангилал	Дохионы хэлтэй нэвтрүүлэг		Хадмал тайлбартай нэвтрүүлэг	
	Дундаж үзүүлэлт	Хамгийн өндөр үзүүлэлт	Дундаж үзүүлэлт	Хамгийн өндөр үзүүлэлт
Өргөн нэвтрүүлгийн телевиз	2.5-4.3%	14.8-18.5%	2.5-2.8%	14.8-15.7%
Арилжааны телевиз	0.5-0.9%	3.1-4.3%	0.8-0.9%	4.3-5.6%

Дээрх Хүснэгт 1-д үзүүлснийг доор арай өөрөөр буюу телевизүүдийн хөтөлбөрт эзлэх дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийг хэдэн телевиз хэдэн хувьтай нэвтрүүлсэн гэдэг үзүүлэлтийг 2025 оны мониторингийн дүнгээр нь авч үзье. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд хамгийн өндөр үзүүлэлт нь дохионы хэл болон хадмал тайлбарын аль ч төрөлд 10% дээш үзүүлэлттэй байгаа сайн талтай хэдий ч энэ нь ердөө 1-2 телевизийн үзүүлэлт юм. Тэгвэл нийт хөтөлбөрийн ердөө 1% ч хүрэхгүй дохионы хэл, бичгэн тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 4-6 телевиз байгаа нь тусгай зөвшөөрлийн ижил ангилалтай телевизүүдийн хувьд нилээд ялгаатай үзүүлэлт үзүүлж байна.

**Хүснэгт 2. Өргөн нэвтрүүлгийн телевизийн тоо
Хөтөлбөрт эзлэх дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн хувиар**

Хөтөлбөрт эзлэх хувь	Дохионы хэлтэй нэвтрүүлгийн хөтөлбөрт эзлэх хувиар, телевизийн тоо	Хадмал тайлбартай нэвтрүүлгийн хөтөлбөрт эзлэх хувиар, телевизийн тоо
10% буюу түүнээс дээш	1-2	1
5% орчим	5-6	2-3
1-3% орчим	21	10-17
1% хүртэл	4-5	4-6
0%	0-1	1-4

**Хүснэгт 4. Арилжааны телевизийн тоо
Хөтөлбөрт эзлэх дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн хувиар**

Хөтөлбөрт эзлэх хувь	Дохионы хэлтэй нэвтрүүлгийн хөтөлбөрт эзлэх хувиар, телевизийн тоо	Хадмал тайлбартай нэвтрүүлгийн хөтөлбөрт эзлэх хувиар, телевизийн тоо
4-5%	0-1	1-3
1-3% орчим	6-17	9-17
1% хүртэл	7	8-9
0%	5-9	6-8

Арилжааны телевизүүдийн хувьд үүрэг хүлээсэн 26 телевизээс 7-9 телевиз хөтөлбөрийнхөө 1% хүрэхгүй дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол 6-8 телевиз огт дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлээгүй байна.

Одоо телевизүүдийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх төлөвлөгөө ирүүлсэн байдал, төлөвлөгөөгөө хэрхэн биелсэн байдалд анализ хийе.

Телевизүүдийн төлөвлөлтийг авахдаа нэвтрүүлгийн нэр, төрөл, үргэлжлэх хугацаа, нэвтрүүлэх тоо, давталтын тоо, тухайн нэвтрүүлгийг дохионы хэлтэй, хадмал тайлбарын аль хэлбэрээр нэвтрүүлэх, энэ нь тухайн телевизийн хөтөлбөрийн хэдэн хувийг эзлэх зэрэг мэдээллүүдийг маягтын дагуу гаргуулан авдаг. Энэхүү төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж үзье. Ийгл нь юс телевизийн жишээнээс харахад тус телевиз нь хамгийн өндөр буюу нийт хөтөлбөрийнхөө 29.4%-ийг дохионы хэлмэрчтэй, 30.6%-ийг хадмал тайлбартай нэвтрүүлэхээр төлөвлөн ирүүлсэн нь тухайн телевизийн нийт хөтөлбөрийн 60%-ийг эзэлж байна. Гэтэл мониторингийн тайлангаар Ийгл нь юс телевизийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувь нийт хөтөлбөрийн 15% орчмыг эзэлж байна. Тухайн телевиз нь өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй, 3 нэвтрүүлгийг бичгэн тайлбартайгаар нэвтрүүлэхээр төлөвлөн ирүүлжээ. Ийгл нь юс телевизийн хөтөлбөрийн мониторингийн тайлангаас харахад төлөвлөгөөний дагуу дээр дурдсан 4 нэвтрүүлгээ дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн төдийгүй нэмэлтээр төлөвлөгөөнд тусгаагүй нэг нэвтрүүлэг хадмал тайлбартай гаргасан байна. Тус телевизийн хувьд төлөвлөгөөгөө гарган ирүүлэхдээ тухайн нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа, нэвтрүүлэх тоо, давталтын тоо зэргийг алдаатай гаргаснаас төлөвлөлт, бодит эфирт нэвтрүүлсэн байдлын хооронд багагүй зөрүү гарч байна.

Энэ мэтчилэн төлөвлөгөөний дагуу нэвтрүүлгүүдээ дохионы хэл, бичгэн тайлбартайгаар нэвтрүүлсэн боловч мониторингийн дүнгээр энэ нь төлөвлөсөн хувь хэмжээндээ хараахан хүрэхгүй байгаа байдал нийтлэг ажиглагдаж байсан. Түүнчлэн 4 телевиз төлөвлөснөөсөө илүү нэмэлт нэвтрүүлгүүд дохионы хэл, хадмал тайлбартайгаар нэвтрүүлсэн нь сайшаалтай байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэх нэвтрүүлгийн төлөвлөлтөө нэвтрүүлгийн нэр тус бүрээр нь харьцангуй зөв гаргасан байна. Харин Сүлд, ТМ телевизүүд төлөвлөгөөнийхөө дагуу огт нэвтрүүлээгүй байна.

Харин Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх хүрээтэй мэдээ, танин мэдэхүйн болон хүүхдэд зориулсан нэвтрүүлэгтэй 26 арилжааны телевизийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх төлөвлөгөө ирүүлсэн байдал, төлөвлөгөөний дагуу хэрхэн нэвтрүүлсэн талаар Хүснэгт 5-д үзүүлээ.

Хүснэгт 5. Арилжааны телевизүүдийн хөтөлбөрөө дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэх төлөвлөгөөнийхөө дагуу нэвтрүүлсэн байдал

Үзүүлэлт	Арилжааны телевизийн тоо
Төлөвлөлтийн дагуу бүрэн нэвтрүүлсэн	6
Төлөвлөсөн төлөвлөлтдөө хүрээгүй	16
Огт нэвтрүүлээгүй	3

Арилжааны телевизүүдийн төлөвлөлт, нэвтрүүлсэн байдлаас харахад дохионы хэлтэй нэвтрүүлнэ гэж төлөвлөсөн нэвтрүүлгээ хадмал тайлбартай нэвтрүүлсэн, эсвэл эсрэгээр нэвтрүүлсэн зэрэг асуудал нилээн хэд гаргасан байсан. Мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн байдал ажиглагдаж байна.

Телевизийн хөтөлбөрийн мониторингийн нэгдсэн дүнгээс харахад дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн нийт цаг тодорхой хэмжээгээр өссөн нь хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ахиц гарч байгааг харуулж байна. Ялангуяа өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд тогтвортой өсөлт үзүүлж байна. Гэвч тухайн телевиз тус бүрийн нийт хөтөлбөрт эзлэх дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн хувь, хэмжээ бага (ихэнхдээ 1–5%-ийн хооронд), хоорондоо харилцан адилгүй байгаа, мөн зарим телевиз огт нэвтрүүлэхгүй байгаа нь зохицуулалт жигд хэрэгжихгүй, байгааг харуулж байна.

Телевизүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад дараах зүйлсийг анхаарч, ажилдаа нэвтрүүлэх нь зүйтэй.

- Телевизүүд өөрсдийн эфирээр нэвтрүүлэх дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэх нэвтрүүлгийн төлөвлөлтөө гаргахдаа ажил хэрэгч хандаж ямар хөтөлбөр, нэвтрүүлгээ дохионы хэлтэй, хадмал тайлбартай гаргааа тодорхойлж, тухайн нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа, давтамж зэргийг сайтар тооцож төлөвлөлтөө үнэн зөв гаргаж ирүүлэх,
- Төлөвлөлтийн дагуу нэвтрүүлгээ нэвтрүүлэхэд гарах зардал, дохионы хэлний хэлмэрчийн хүрэлцээ зэргийг тооцох,
- Орчин үеийн дэвшилтэт технологи, шийдлийг нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх,
- ХХЗХ-оос үйлчилгээ эрхлэгчид рүү сар бүр илгээж, цахим хуудсаараа тогтмол мэдээлдэг мониторингийн тайлан, мэдээтэй тогтмол танилцаж, хянадаг байх,
- Зөвхөн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн хөтөлбөрөөр хязгаарлахгүйгээр бусад төрлийн сонирхолтой цэнгээнт хөтөлбөр, кино зэргийг хадмал тайлбартай нэвтрүүлэх.

Хүн бүрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн форматаар мэдээллийг тэгш хүртээмжтэй хүргэх нь бэрхшээлгүй хөгжих боломжийг олгодог.

--оОо--